



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ
№2

2017 ОНЫ 10 САР



*"Сурахаа зогсоовол 20 настай ч
80 настай ч хөгширнө. Харин
үргэлж сурч байдаг хүн үргэлж
залуу байдаг." Хенри Форд*



ТОВЧ АГУУЛГА

Насан туршдаа суралцах санаа цоо шинэ зүйл биш юм. Эртний философич Платон өөрийн алдарт “Төр улс” зохиолдоо хүний амьдралын тодорхой үе шатанд шаардагдах боловсролын загварыг дэвшүүлсэн нь өнөөгийн “насан туршийн боловсрол”-ын үзэл санааны үндэс байжээ. 1967 онд АНУ-ын Уильямсбергэд болсон олон улсын бага хурлаар ЮНЕСКО-ийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэнгийн анхны захирал Филип Коомбсийн бэлтгэсэн “Боловсролын салбарт гарч буй дэлхий нийтийг хамарсан хямрал: Системийн анализ” –ын тухай илтгэлийг хэлэлцээд

Насан туршийн боловсролын тухай үзэл баримтлалыг ЮНЕСКО-оос 1972 онд гаргасан Эдгар Форийн “Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол” (Faure Report, 1972) бүтээлд анх гаргаж тавьсан юм. Харин 1996 оны Жак Делорын “Боловсрол: түүнд нуугдсан эрдэнэс” (Delors Report, 1996) гэсэн бүтээлд боловсролд өвчөөр нэгдмэл хандаж, насан туршийн боловсрол ба суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчмыг тус тус тодорхойлжээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1996 онд “Бүх нийтийн насан



Сурахаа зогсоовол 20 настай ч 80 настай ч хөгширнө.
Харин үргэлж сурч байдаг хүн үргэлж залуу байдаг.

- *Женри Дорд* -

улс орны эдийн засгийн хөгжил, боловсрол хоорондын уялдаа холбоо суларч сургалтын хөтөлбөрүүдийн нийгмийн ач холбогдол бага болсныг хурцаар шүүмжилж, боловсролын систем нийгэм эдийн засгийн шаардлагад хөл нийлүүлэн алхах үйл явц удаашралтай болж байгааг хүлээн зөвшөөрчээ. Үүний дараагаар Дэлхийн банкны эдийн засагчид, удирдагч нар албан ба албан бус боловсролыг ялгаж авч үзэх болжээ. ЮНЕСКО, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Европын холбоо зэрэг байгууллагууд насан туршийн боловсролыг дэлгэрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн байна.

туршийн боловсрол” илтгэлийг хэвлэн нийтлүүлж, нийгмийн өмнө тулгарч байгаа эдийн засаг, нийгэм, соёл, хүрээлэн байгаа орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсролын асуудлыг хамтад нь авч үзэхийг анхааруулсан байна. Европын холбооноос мэдлэгийн эдийн засаг бий болгох зорилгынхоо хүрээнд 2000 оноос насан туршийн боловсролын талаар өргөн хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм. 2000 онд Европын холбоо насан туршийн боловсролын тухай санамж бичиг, 2002 онд Европын зөвлөлөөс насан туршийн боловсролын талаар тусгай шийдвэр гаргасан бол 2006 онд Европын парламент 2007-2013 он хүртэл насан туршийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг дэмжсэн байна. ЮНЕСКО-ийн



Насан туршийн боловсролын тухай үзэл баримтлалыг ЮНЕСКО-оос 1972 онд гаргасан Эдгар Форийн "Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол" (Faure Report, 1972) бүтээлд анх гаргаж тавьсан юм.



Жак Делорын "Боловсрол: түүнд нуугдсан эрдэнэс" (Delors Report, 1996) гэсэн бүтээлд боловсролд өвчөөр нэгдмэл хандаж, насан туршийн боловсрол ба суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчмыг тус тус тодорхойлжээ.



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1996 онд "Бүх нийтийн насан туршийн боловсрол" илтгэлийг хэвлэн нийтлүүлж, нийгмийн өмнө тулгарч байгаа эдийн засаг, нийгэм, соёл, хүрээлэн байгаа орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсролын асуудлыг хамтад нь авч үзэхийг анхааруулсан байна.



Европын холбооноос мэдлэгийн эдийн засаг бий болгох зорилгынхоо хүрээнд 2000 оноос насан туршийн боловсролын талаар өргөн хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм.



Европын парламент 2007-2013 он хүртэл насан туршийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг дэмжсэн байна.



Малайз улсын 2011-2020 он хүртэлх "Насан туршийн боловсролын соёлыг хэвшүүлэх төлөвлөгөө"-нд насанд хүрэгчдийн боловсрол, мэргэшил дээшлүүлэхэд илүүтэй анхаарсан байна.



АНУ-ын Уильямсбергэд болсон олон улсын бага хурлаар Филип Коомбсийн бэлтгэсэн "Боловсролын салбарт гарч буй дэлхий нийтийг хамарсан хямрал: Системийн анализ" –ын тухай илтгэлийг хэлэлцээд улс орны эдийн засгийн хөгжил, боловсрол хоорондын уялдаа холбоо суларч сургалтын хөтөлбөрүүдийн нийгмийн ач холбогдол бага болсныг хурцаар шүүмжилж, боловсролын систем нийгэм эдийн засгийн шаардлагад хөл нийлүүлэн алхах үйл явц удаашралтай болж байгааг хүлээн зөвшөөрчээ.



Монгол Улсын төрөөс иргэдийнхээ насан туршид сурч хөгжих хэрэгцээг албан болон албан бус боловсролын нэгдлийг боловсронгуй болгох замаар хангана гэж үзээд Боловсролын тухай хуулинд "Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна" гэж заасан юм.



Монгол улсын Засгийн газраас "Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" баталсан байна.



Европын зөвлөлөөс насан туршийн боловсролын талаар тусгай шийдвэр гаргасан байна.



Монгол Улсын төрөөс иргэдийнхээ насан туршид сурч хөгжих хэрэгцээг албан болон албан бус боловсролын нэгдлийг боловсронгуй болгох замаар хангана гэж үзээд Боловсролын тухай хуулинд "Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно" гэж заасан юм.



Монгол улсын Засгийн газраас Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамнаас "Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого"-ыг баталсан байна.



Энэтхэг улсын "Ур чадварыг хөгжүүлэх үндэсний санаачлага" нь насан туршийн боловсролоор ажил эрхлэх тодорхой ур чадварыг хөгжүүлэхэд анхаарсан байна.



Насан туршийн боловсролын хүрээлэнгээс насан туршийн боловсролын талаар гишүүн орнуудын баримталж байгаа бодлого, стратегийн баримт бичгийн тусгай онлайн сан бий болгосон байна. Энэ санд насан туршийн боловсролын талаарх улс орнуудын 60 гаруй бодлогын баримт бичиг байгаа бөгөөд тэднийг судалж үзэхэд насан туршийн боловсролын талаар нэгдмэл ойлголт байхгүй бөгөөд олон янзын тайлбар тодорхойлолт байгааг илрүүлсэн байна. Судалгаанаас харахад Ази Номхон далайн орнуудын хувьд насан туршийн боловсролд чиглэсэн бодлого, стратегийн олон тооны баримт бичиг байгаа бөгөөд юуны өмнө насанд хүрэгчдийн боловсрол, ур чадварын хөгжилд илүүтэй анхаарал хандуулсан байна. Тухайлбал, Энэтхэг улсын “Ур чадварыг хөгжүүлэх үндэсний санаачлага” нь насан туршийн боловсролоор ажил эрхлэх тодорхой ур чадварыг хөгжүүлэхэд анхаарсан байхад Малайз улсын 2011-2020 он хүртэлх “Насан туршийн боловсролын соёлыг хэвшүүлэх төлөвлөгөө”-нд насанд хүрэгчдийн боловсрол, мэргэшил дээшлүүлэхэд илүүтэй анхаарсан байна.

Европын холбооны тухайлбал, Болгар, Унгар, Латви, Словак зэрэг олон тооны гишүүн орнуудын хувьд 2000 оны Европын холбооны насан туршийн боловсролын тухай санамж бичгийн үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэсэн насан туршийн боловсролыг хөгжүүлэх бодлогын бичиг баримт боловсруулж хэрэгжүүлж байна. Монгол Улсын төрөөс иргэдийнхээ насан туршид сурч хөгжих хэрэгцээг албан болон албан бус боловсролын нэгдлийг боловсронгуй болгох замаар хангана гэж үзээд Боловсролын тухай хуулинд “Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна” (1995 он), “Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно” (2002 он) гэж заасан юм. Тухайн хуулийг хэрэгжүүлэх үүднээс Монгол улсын Засгийн газраас 1997 онд “Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, 2010 онд Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамнаас “Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах

бодлого”-ыг тус тус баталсан байна. Албан бус боловсролын 400 орчим “Гэгээрэл” төвүүдийг дүүрэг, аймгуудад байгуулж, гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, ёс суртахуун төлөвшлийн боловсрол, гоо зүй- мэдрэмжийн боловсрол, амьдрах ухааны боловсрол гэсэн 5 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр баримт бичиг болон “Гэгээрэл” төвүүдийн үйл ажиллагааг судалж үзэхэд насан туршийн боловсролыг албан бус боловсролоор орлуулах хазгай ойлголт байна.

Насан туршийн боловсролоор дээд боловсрол эзэмших боломжийг зайнаас захидлаар харилцан суралцах сургалт олгодог байсан бол сүүлийн жилүүдэд мэдээлэл, холбооны технологийн ачаар нээлттэй, виртуаль их сургууль байгуулах, сургалтын материалыг олон нийтэд нээлттэй сүлжээнд байрлуулах, нийтийг хамарсан нээлттэй онлайн сургалтууд явуулах зэргээр өргөн хүрээтэй болгожээ. Нээлттэй их сургуулиуд олноор байгуулагдсанаар насан туршийн боловсролын асуудлыг олон улс оронд цоо шинээр харах болсон юм. Нээлттэй их сургуулийн оюутны дийлэнх хэсэг нь их сургуулийн зэрэг, диплом авах сургалтанд хамрагддаг бол нөгөө нэг хэсэг нь насан туршийн боловсролоор өөрсдийн мэдлэг чадвараа цаашид улам дээшлүүлэх зорилготой сурдаг байна. Нээлттэй их сургуулиуд нь юуны өмнө их дээд сургуульд элсэж чадаагүй оюутнуудыг өмнөх сургалтын үр дүнг үл харгалзан нээлттэй хамруулдаг бөгөөд уламжлалт их дээд сургуулиудад заадаг хичээлүүдээс гадна хувь хүнийг хөгжүүлэх, ажил мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд чиглэсэн хичээлүүдээс сонгон, цаг хугацаа, оршин суугаа газраас үл хамааран суралцах нээлттэй боломж олгодгоороо насан турш сурч боловсрох соёлыг олгож байдаг.

ШУТИС нь насан туршийн боловсролыг хөгжүүлэх суурь бодлогыг бий болгох чиглэлд тодорхой ажлуудыг санаачлан хийж байна. Тухайлбал OER, MOOC, online content бэлтгэх, дэд бүтцийг бий болгох гэх мэт.

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ОНЦЛОГ

1 ТОДОРХОЙЛОЛТ

Насан туршийн боловсролын тухай олон янзын тодорхойлолт байдаг. 1997 оны сүүлээр АНУ-д засгийн газар, бизнес, хөдөлмөрийн байгууллага, боловсролын салбарын эрдэмтдийн бүрэлдүүнтэй байгуулагдсан тусгай ажлын хэсгээс насан туршийн боловсролыг дараах байдлаар тодорхойлсон байна. “Насан туршийн боловсрол бол хүний амьдралын туршид шаардагдах мэдлэг, чадвар, ойлголт, зан чанарыг олгох, улмаар түүнийгээ ямар ч орчин нөхцөлд өөртөө итгэлтэй, урам зоригтой бүтээлчээр хэрэглэж чадах чадамжийг суулгах замаар хувь хүнийг нийгэмд идэвхитэй байр суурь эзлэхэд нь дэмжлэг үзүүлж, чадваржуулж байдаг

тасралтгүй, дэм үйл ажиллагаа юм гэжээ.” Энэ тодорхойлолтоос үзэхэд насан туршийн боловсрол бол тасралтгүй, дэм үйл ажиллагаа гэдэг нь хэзээ ч зогсдоггүй, гэхдээ дангаараа явагддаггүй, хувь хүний хүсэл эрмэлзлэлд хөтлөгдсөн үйл ажиллагаа гэжээ. Мөн сонгосон мэргэжлийнхээ хүрээгээр хязгаарлагдахгүй, амьдралын бүхий л нөхцөлд анх амьсгалж эхэлснээс амьсгалаа хураатал шаардлагатай мэдлэг чадвар, зан чанарын хэм хэмжээний талаар зөвхөн мэдээд зогсохгүй, түүнийгээ үрөгөөжтэй хэрэглэж, түүнээсээ сэтгэлийн ханамж авч чаддаг байх гэсэн санааг агуулж байна.





2 НАСАН ТУРШ СУРАЛЦАХ ХЭЛБЭРҮҮД

Насан туршийн боловсрол бол албан, албан бус болон амьдралын орчноос бие даан суралцах гэсэн 3 үндсэн хэлбэр загвараас тогтдог. Боловсролын эдгээр загваруудын ач холбогдлыг танин мэдэхийн тулд гол ялгааг нь авч үзье.

Албан боловсрол бол нарийн зохион байгуулалттай, улсын бүртгэлтэй сургалтын байгууллагад улсаас баталсан сургалтын хөтөлбөрөөр шат дараалан суралцаж, олж авсан мэдлэг чадвараа улсаас хүлээн зөвшөөрсөн бүрэн дунд боловсролын аттестатаас эхлэн мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшсэн дипломоор баталгаажуулах үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол бол боловсрол олгох тусгай зориулалттай орчноос гадуур тодорхой зорилготой, тодорхой арга зүй хэрэглэн мэдлэг чадвар олгох үйл ажиллагаа юм. Боловсролын болон олон нийтийн байгууллага, янз бүрийн дугуйлан, клуб, тусгай төв зэргээс явуулж байгаа сургалт, семинар, дамжаа энд хамрагдах бөгөөд мэргэжил дээшлүүлснийг баталгаажуулсан

диплом, сертификатыг төгсгөлд нь олгодог байна. Сүүлийн жилүүдэд албан бус боловсролыг нийтийг хамарсан нээлттэй онлайн сургалтад хамрагдан олж авах боломж улам бүр өсөн нэмэгдэж байна.

Амьдрах орчноос бие даан суралцах нь хүний өдөр тутмын амьдралд тохиолдож байдаг танин мэдэхүйн үйл ажиллагаа юм. Хүмүүс өөр хоорондоо харилцан ярилцах, санаа бодлоо солилцох, нийгмийн сүлжээнд холбогдон бусдаас шинэ мэдлэг мэдээлэл олж авах, ном унших, театрт жүжиг кино үзэх, үзэсгэлэн музей үзэж танилцах, соёлын бусад байгууллагаар орж үйлчлүүлэх, аялал жуулчлалаар явах замаар бусад улс орон, газар нутагтай танилцах, хэвлэл мэдээллийн хэрэгслээс шинэ мэдээлэл сонсож, мэдэх зэргээр хувь хүн өөрийгөө улам цаашид хөгжүүлж байдаг. Мөн ажил дээрээ байнга шинийг олж мэдэж, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлж байдаг. Өнөөдөр сургалтын материалыг нээлттэй хэлбэрээр сүлжээнд байрлуулах болсон нь хувь хүн бие дааж сурах бас нэг нөхцөлийг бүрдүүлэх болжээ.

3 НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛҮҮД

Насан туршийн боловсрол нь хүмүүнлэгийн болон эдийн засгийн гэсэн 2 үндсэн чиглэлтэй байна. Хүмүүнлэгийн чиглэлтэй насан туршийн боловсролыг хөгжүүлэх бодлого нь хувь хүн, хамт олныг төлөвшүүлэн хөгжүүлэх, өөрчлөхөд чиглэж байхад эдийн засгийн хандлага нь насан туршийн боловсролыг мэдлэгийн эдийн засгийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгоход чиглэж байна. Улс төрчдийн зүгээс насан туршийн боловсролыг эдийн засгийн өрсөлдөөн, зах зээлийн аюулгүй байдлын талаас

илүүтэй авч үзээд хүний нөөцийн хөгжлийг дэмжих, ажил эрхлэх илүү өндөр чадварыг бий болгох үндэс гэж үзэх талтай. Гэхдээ насан туршийн боловсролын бодлогыг аль болохоор энэ хоёр хандлагыг тэнцүү харгалзан үзэж боловсруулах нь нийгмийн тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ. Манай оронд мөрдөж байгаа өнөөгийн албан бус боловсролын төрийн бодлого нь хүмүүнлэгийн чиглэлийг баримталж байна.

4 СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЗАРЧИМ, АРГА ХЭРЭГСЭЛ

Насан туршийн боловсрол нь албан боловсролоос гадна албан бус боловсрол, ажил дээрээ, амралт чөлөөт цагаараа, гэр бүл, хамт олны хүрээнд амьдрах орчноос бие даан суралцаж

боловсрол олж авах хэлбэрүүдийг багтааж байдаг учраас албан бус болон, амьдралын орчноос олж авсан боловсролын үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах асуудал

чухлаар тавигдаж байдаг. Өөрөөр хэлбэл, албан боловсролоос гадуур олж авсан мэдлэг, чадварыг үнэлж, харгалзах хичээлийн кредитийг тооцохоос эхлээд тодорхой мэргэжил, мэргэшил эзэмшихэд шаардлагатай мэдлэг чадварын стандартыг хангасан тохиолдолд мэргэшлийн зэрэг, тэр ч байтугай боловсролын зэрэг олгох боломжтой юм. Энэтхэг, Дани, Чили зэрэг улс орнуудын насан туршийн боловсролын бодлогын баримт бичигт албан бус болон, амьдралын орчноос олж авсан боловсролын үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх асуудлыг

хөндсөн байна. Дани улсын иргэд 2007 оны 556-р хуулийн дагуу албан бус боловсролоор болон амьдралын явцад олж авсан өөрийн мэдлэг, чадвар, чадамжаа хүлээн зөвшөөрүүлэхээр боловсролын байгууллагад хандах эрхтэй болжээ. Норвеги улсад боловсролын ямар хэлбэрээс олж авснаас үл хамааран хувь хүний “realkompetanse” буюу жинхэнэ чадамжийг үнэлэхийг хуульчлан заасан байна. Өмнөд Солонгост “сургалтын кредитийн сан” бий болгож, кредит тооцох боломжийг нээж өгчээ.



Сургалтын үр дүнг үнэлэх асуудал бол маш нарийн зохион байгуулалттай, ил тод, шударга

зарчмаар явагддаг үйл ажиллагаа бөгөөд гол төлөв дөрвөн үе шаттай хэрэгждэг.

A

Нэгдүгээрт, албан боловсролын болон мэргэжил, мэргэшлийн мэдлэг олж байгууллагаас гадуур албан бус сургалтанд авсан гэж үзээд түүнийгээ баталгаажуулахаар хамрагдаж, эсвэл бие дааж тодорхой хичээл хүсэлт гаргасны дагуу харгалзах хичээл,



мэргэжил, мэргэшлээр зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг чадвар чадамжийн стандартыг тодорхойлж гаргана. Тухайн тодорхой хичээл, мэргэжил, мэргэшлээр зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг чадвар чадамжийн стандартыг Португали улсад Мэргэшлийн асуудал эрхэлсэн

B

Хоёрт, хүсэлт гаргасан хүн зохих мэдлэг чадвар чадамжийг эзэмшсэнийг батлах баримт нотолгоогоо гаргаж мэдүүлнэ. Зохих мэдлэг чадвар чадамжийг эзэмшсэнийг батлахын тулд Франц улсад нотлох баримт бичгийг судлах, практик дээр мэргэшлийн тодорхой даалгаврыг гүйцэтгэж чаддагаа харуулах гэсэн хоёр аргыг хэрэглэдэг байна. Харин сүүлийн үед нотлох баримтын портфолио хэрэглэх болжээ. Энэхүү портфолиод албан ёсны гэрчилгээ,

үндэсний агентлаг тодорхойлдог бол Шинэ Зеланд улсад мэдлэг чадвараа баталгаажуулах өргөдөл гаргасан хүн бүртэй ярилцлага хийж, ямар мэргэжил, мэргэшлийн чиглэлд илүү ойр болохыг нарийвчлан тогтоодог байна.

дипломоос гадна, хийсэн ажлын жишээ, ажлын үр дүнгийн тайлан, ажил эрхлэгчдээс өгсөн үнэлгээ, эрхэлж байсан болон хийж байгаа ажлын байрны тодорхойлолт, хамрагдсан сургалтын талаарх мэдээлэл, бүтээлийн жагсаалт, шагнал, урамшуулал, тодорхойлолт, видео, фото баримт зэрэг бүх төрлийн нотолгоо болохуйц материалуудыг бүрдүүлэн оруулна. Мөн Дани, Өмнөд Африк зэрэг улс орнуудад ийм практик хэрэглэдэг байна.

C

Гуравт, хүсэлт гаргасан хүний мэдлэг чадвар чадамжийг шалгалт авч үнэлнэ. Гол төлөв албан боловсролд хэрэглэдэг мэдлэг чадварыг үнэлэх систем, тухайлбал, бичгийн болон ам шалгалт авах замаар албан бус болон бие даан эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлдэг байна. Францад шалгалтын комисс ярилцлага авах замаар мэдлэг чадварыг үнэлдэг бол Канад улсад тест авах төдийгүй практик чадварын шалгалт авдаг нь олны анхаарлыг татаж байна. Бельги улсад портфолиод тулгуурласан үнэлгээний

аргыг хэрэглэдэг байна. Үүнд, нэгд суралцаж дүүргэсэн дамжаа, курсын гэрчилгээ, дүнг харгалзахын дээр тухайн мэргэшилтэй уялдаатай дөрвөөс доошгүй өөрийн хийсэн төсөл, ажлыг танилцуулж хамгаалдаг байна. Норвеги улсад харилцан ярилцлага явуулж, портфолио судалж үнэлдэг байна. Тайланд, Пакистан, Чилид төрийн тусгай байгууллага үнэлгээг явуулдаг бол Японд гуравдагч хөндлөнгийн байгууллага үнэлгээ явуулдаг байна.

D

Эцэст нь албан бус болон бие даан олж авсан мэдлэгийг үнэлж, дүгнэсний дараа кредит, диплом, боловсролын болон мэргэшлийн зэрэг олгох замаар баталгаажуулдаг. Өмнөд Солонгос улсад боловсролын кредитийн бааз

бий болгосон байна. Францад Мэргэшлийн үндэсний бүртгэл, Дани улсад Чадамжийн портфолио, Герман улсад Profil-PASS, Норвеги улсад хувь хүний чадамжийн баримт зэрэг олон төрлийн арга механизмуудыг хэрэглэдэг байна.

БАРИМТ 1 - ФИНЛЯНД - НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Албан бус ба амьдралын орчноос бие даан суралцаж олж авсан мэдлэг чадварыг магадлан итгэмжлэх хууль эрх зүйн орчныг Финлянд улс сайн боловсруулж, хэрэгжүүлж байна. Эдгээр хуулийн үндсэн санаа нь хаана хэзээ яаж олж авснаас үл хамааран хувь хүн өөрийн мэдлэг чадвараа үнэлүүлж

баталгаажуулах эрхтэйд оршино. Хувь хүний мэдлэг чадварыг магадлан баталгаажуулах үйл ажиллагаа 3 үе шаттай явагддаг байна. Эхний үе шатанд өөрийн мэдлэг чадвараа үнэлүүлэх, баталгаажуулах талаар өргөдөл гаргана. Энэ үе шат нь өргөдөл гаргагчдад тодорхой мэдээлэл өгч, нэмэлт сургалт

шаардлагатай эсэхийг тогтоож, олж авсан мэдлэг чадварыг урдчилан тогтоож өгдөг. Хоёрдахь үе шатанд чадамжийг үнэлэх үйл ажиллагаа явагдана. Өргөдөл гаргах шатны зөвлөмжийн үр дүнгээс хамаарч хангалттай батлах нотолгоо байгаа бол зарим мэдлэг мэргэжлийн үнэлгээг шууд тооцож болох ба тухайн хүнд зориулсан чадамжийг үнэлэх сорилыг тодорхойлдог. Ажил мэргэжлийн тодорхой ур чадварыг ажил дээр сургах, эсвэл дадлага хийлгэх замаар олгож бас болдог байна. Энэ бүх үйл ажиллагааг нарийн бүртгэж баримтжуулдаг. Эцэст нь Мэргэжлийн комиссоос тухайн хүний мэдлэг чадвар, чадамжийг үнэлсэн гэрчилгээ олгодог байна.

Энэ үйл ажиллагаа бараг үнэ төлбөргүй байдаг. Түүнээс гадна Ажил олгогчдын холбооноос ажил хайгчдад зориулсан тусгай веб сайт ажиллуулж, ур чадварын аудит хийж, зөвлөлгөө тусламж үзүүлдэг байна. Финляндын хөдөлмөрийн зах зээлийн түншүүд нь “Боловсролын сан” байгуулж, олон жил ажил эрхэлсэн хүмүүст ур чадвар, чадамжаа дээшлүүлэхэд нь зориулж дээд тал нь 19 сарын турш санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна. Түүнээс гадна өндөр ур чадвартай ажилчдад өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн шалгалтаар өндөр үнэлгээ авсан хүмүүст зориулсан сургалтын тэтгэлэг бас олгодог байна.



НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААР ГАРЧ БАЙГАА САНААЧЛАГУУД

1 НАСАНД ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛ

Насанд хүрэгчдийн боловсрол бол 230 гаруй жилийн түүхтэй юм. Анх 1700 оны үеэс шинэ ажилчдыг ажлын ихээхэн туршлагатай ажилчдыг дагалдуулан сургаж, тодорхой ажил хийх ур чадварыг олгож байсан нь насанд хүрэгчдийн боловсролын эхний илрэл байжээ. 1800 оны үеэс насанд хүрэгчдэд зориулсан боловсролын байгууллагууд бий болсон байна. Энэ үед Chaupaqua хэмээх хөдөлгөөн гарч, тосгоноос тосгон

дамжин хичээл зааж, лекц уншдаг бүлгүүд бий болсон байна. 1900 оноос Засгийн газруудаас насанд хүрэгчдийн боловсролын талаар онцгой анхаарал тавьж, эрх зүйн үндсийг тавьж эхэлсэн байна. Өнөө үед насанд хүрэгчдийн боловсролын асуудлыг насан туршийн боловсролын хүрээнд авч үзэх болжээ. ЮНЕСКО дөнгөж байгуулагдсанахаа дараа 1949 онд насанд хүрэгчдийн боловсролын талаар олон улсын анхны бага хурлаа Дани улсын



Хелсингор хотноо хийсэн байна. ЮНЕСКО-гоос зохиосон насанд хүрэгчдийн олон улсын бага хурал нь урд өмнө нь насанд хүрэгчдийн боловсролын асуудлаар зохиогдож байсан бага хурлаас агуулга, хамарч буй сэдвийг өргөн хүрээнд иж бүрнээр авч үзсэнээрээ онцлог талтай байжээ. Түүнээс хойш 12 жил тутам насанд хүрэгчдийн боловсролын асуудлаар бага хурал (CONFINTEA)-аа зохиож ирсэн байна. 1960 онд Канадын Монреалд, 1972 онд Японы Токиод, 1985 онд Францын Парист, 1997 онд Германы Гамбург хотод тус тус зохиосон байна. Сүүлийн 6 дахь CONFINTEA бага хурлыг Бразилийн Белем хотноо 2009 онд зохион байгуулсан байна. Нөгөө талаас 1950 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага чуулганаас Хамбург хотноо Боловсролын Хүрээлэн байгуулсан байна. Энэ хүрээлэн нь сургуулийн өмнөх наснаас насанд хүрэгчдийн боловсролын асуудлыг хариуцдаг байжээ. 2006 онд энэ хүрээлэнг насан туршийн боловсролын хүрээлэн болгон нэрийг нь өөрчилсөн байна. Энэ хүрээлэн нь насан туршийн боловсролын бодлогын асуудлаар судалгаа шинжилгээний ажил явуулахын зэрэгцээ насанд хүрэгчдийн боловсролын олон улсын бага хурал

CONFINTEA-г зохион байгуулж, түүнээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажилд мониторинг хийх ажлыг хариуцдаг байна. Мөн насанд хүрэгчдийн боловсролын асуудлаар дэлхийн тайлан (GRALE)-г 2009 оноос гаргаж эхэлсэн байна. 2016 онд гарсан гурав дахь тайлангийн асуулгад манай улсаас өгсөн хариулт ихээхэн анхаарал татаж байна. Тухайлбал, манайд насанд хүрэгчдийн боловсролын талаар албан ёсны тодорхойлолт байхгүй, түүний үр дүнгийн талаар үнэлэх боломжгүй зэрэг хариулт өгснөөс үзвэл насан туршийн боловсролын бодлогын хүрээнд насанд хүрэгчдийн боловсролын асуудлыг нухацтай хөндөж авч үзэх шаардлага байна. Манай оронд 1956 оноос багш нарын мэргэжил дээшлүүлэх институт байгуулж байсан нь насанд хүрэгчдийн боловсролын нэг хэлбэр юм. Түүнээс гадна Политехникийн дээд сургуульд наяд оны үед мэргэжил дээшлүүлэх салбар байгуулан ажиллаж, үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа инженер эдийн засагчдад удирдлага зохион байгуулалт болон техник технологийн шинэ ололт амжилттай танилцуулж байсан юм.

2 ЗАЙН СУРГАЛТ –НЭЭЛТЭЙ ИХ СУРГУУЛИУД

1800 оны сүүлээр сургуульд тогтмол явж, хичээлдээ бүрэн сууж чадахгүй хүмүүст зориулж зайнаас шуудангаар харьцаж, суралцах боломжийг олгож эхэлсэн байна. Суралцагчид сургууль дээрээ богино хугацааны чиглүүлэх лекцийн хичээлд оролцож, хичээлийн материал, гэрийн даалгаврыг нь шуудангаар солилцож, улмаар шалгалтуудаа сургууль дээрээ ирж өгөх замаар зайн сургалтыг явуулдаг байжээ. Түүнээс хойш багш суралцагчдын хоорондын үйл ажиллагааг ойртуулах талаар радио, телевиз зэрэг төрөл бүрийн технологи хэрэглэх болсон бол хорьдугаар зууны сүүлээс мэдээллийн технологийн хөгжлийн ачаар компьютер, интернет зэрэг ашиглан сургалт явуулах болсон байна. Зайн сургалтын өөр нэг сонирхолтой хэлбэр бол нээлттэй их сургуулиудыг байгуулж ажиллуулах болсон явдал юм. Их Британид анхны нээлттэй их сургуулийг 1969 онд байгуулсан байна. Энэ их сургууль нь 250 мянга гаруй оюутантай, түүний

32000 нь 25-аас доош насны залуучууд, 50000 нь гадаадын оюутан байна. Энэ их сургуульд элсэхэд нээлттэй бөгөөд ямар нэг шаардлага тавьдаггүй байна. 1000 гаруй профессор багш нарын дотор ерөнхий сайд асан Гордон Браун зэрэг нэртэй хүмүүс байдаг бол 2 сая төгсөгчдийн дундаас олон тооны урлагийн авьяастнууд, эрдэмтэд, улс төрийн зүтгэлтнүүд төрөн гарчээ. Хамгийн гол нь энэ их сургууль нь сургалтын чанараараа Их Британид эхний 5-д ордог бөгөөд дэлхийн их сургуулиудын дунд чансаагаараа эхний 50-д багтдаг байна. Өнөөдөр Энэтхэгийн Индра Гандийн нээлттэй их сургууль нь 4 сая гаруй оюутантай хамгийн том мега их сургууль болжээ. Түүнээс гадна Өмнөд Солонгосын Үндэсний нээлттэй их сургууль, Малайзийн Вавасан нээлттэй их сургууль, Канадын Атабасийн нээлттэй их сургууль гээд олон тооны нээлттэй их сургуулиуд амжилттай ажиллаж байна.

4'000'000 оюутан



Энэтхэгийн
Индра Гандийн
нээлттэй их
сургууль

250'000 оюутан



Их Британий
нээлттэй их
сургууль

180'000 оюутан



Өмнөд
Солонгосын
Үндэсний
нээлттэй их
сургууль,

40'000 оюутан



Канадын
Атабасийн
нээлттэй их
сургууль

10'000 оюутан



Малайзийн
Вавасан
нээлттэй их
сургууль

3 ЭРДЭМТЭЙ ОЮУНЛАГ НИЙГЭМ

Мэдээллийн технологийн эрчимтэй хөгжил, олон улсын хамтын ажиллагааны өсөлт, даяаршлал нь мэдлэгийн эрин зуунд шилжих үндсэн шалтгаан бөгөөд түүнд нийгмийн зүгээс бэлтгэх үндсэн нөхцөл бол мэдлэг боловсролыг шүтэн дээдэлж, ард иргэдээ эрдэм мэдлэгээр өвч цэнэглэх явдал гэдгийг ХХ зууны сүүлээс дэлхийн олон орон ухаарч мэдэрсэн юм. Нийгмийн энэхүү дуудлагад барих нэг хариу бол нийгмээрээ эрдэмтэй оюунлаг болох явдал гэж үзэж байна. 2000 оны үед Европын Холбоо Эрдэмтэй оюунлаг нийгэм байгуулах талаар зөвлөмж гаргаж байжээ. Нийгмээрээ эрдэмтэй

оюунлаг болох үндэс нь хот суурингаас эхэлбэл илүү үр дүнтэй гэж үзээд 2013 онд ЮНЕСКО-гоос Бээжин хотноо Эрдэмтэй оюунлаг хотуудын анхдугаар бага хурлыг зохион байгуулсан байна. Энэ бага хурлаас Эрдэмтэй оюунлаг хотуудын сүлжээ байгуулахыг дэмжсэн байна. 2017 оны 5 сарын 01-ний байдлаар 42 орны 188 хот энэ сүлжээнд нэгдсэн байна. 2017 оны 9 сард Эрдэмтэй оюунлаг хотуудын олон улсын III бага хурал Ирландын Корк хотноо зохион байгуулагдсанд дэлхийн 80 гаруй орны төлөөлөгчид оролцжээ.

БАРИМТ 2 - КОМИНКАН – ХОРОО ХОТООРОО СУРАХ ОРЧИН

Дэлхийн 2-р дайны дараа Японы төр засгаас улс орноо сэргээн босгох үүднээс хүмүүнлэгийн боловсролын тухай хууль гаргасны хүрээнд 1940 оны сүүлээс Коминкан нэртэй соёлын төвүүдийг байгуулж ажиллуулсан байна. Өнөөдөр 16000 орчим ийм төв байгуулагдан ажиллаж байгаад жилдээ 300 мянга орчим хүн хамрагддаг байна. Ийм төв нь өөрийн гэсэн байртай, мөн дарга, сургалтын зохицуулагч гэсэн 3 орон тоотой ажилладаг бөгөөд

орон нутгийн төсвөөс бүрэн санхүүждэг байна. Эдгээр төвүүдэд хоол хийхээс гадна таталган бичигт сурах, хүрээлэн байгаа орчноо хамгаалах, хүний эрхийн тухай, залуу гэр бүл, залуу эхчүүдэд зориулсан сургалт зэрэг маш олон төрлийн сургалт явуулдаг байна. Мөн тухайн орон нутагт тулгамдаж байгаа асуудлаар сургалт явуулах, тэр бүү хэл гэрчилгээ диплом олгох сургалтыг явуулдаг байна.



Kominkan

БАРИМТ 3 - 1-2-3 ДЭД БҮТЭЦ

Өмнөд Солонгос улсын 35 хот ЮНЕСКО-ийн Эрдэм оюунлаг хотуудын сүлжээнд орсны нэг сонирхолтой жишээ бол Намянжу хот юм. Сеулээс холгүй байрлах энэ хотын хүрээлэн буй орчин амьдрахад таатай, орон сууцны үнэ харьцангуй хямд учраас 2011 оноос 2015 он хүртэл хүн амынх нь тоо 23.4 хувиар өсжээ. Хотын дийлэнх хүмүүс Сеулд ажилладаг учраас амьдардаг орон нутагтаа гэрсэж бараг чаддаггүй ажээ. Өөрийн оршин сууж байгаа хотдоо сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэх нэг үндэс бол насан туршийн боловсрол гэж үзээд 1-2-3 гэсэн төслийг хотын удирдлагаас хэрэгжүүлсэн байна. 1 гэдэг нь иргэн бүр “Эрдмийн цамхаг” гэгдэх сургалтын төвөөс 10 минутаас холгүй амьдрах, 2 гэдэг нь томоохон сургалтын төвүүд 20 минутаас холгүй зайд байх, 3 гэдэг нь номын сан 30 минутаас холгүй байх гэсэн санаагаар зохих дэд бүтцийг бий болгосон байна. “Эрдмийн цамхаг” хэмээх сургалтын төв нь сургалт явуулахын зэрэгцээ

тухайн дүүрэг хорооны хүмүүс уулзаж өөрсдийн амьдралынхаа тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцох орон зайг олгодог байна. Түүнээс гадна хотын иргэдийнхээ мэргэшлийн чадавхийг дээшлүүлэх, тэдний авьяас чадварыг хөхүүлэн дэмжихийн тулд Хотын Академи хэмээх сургалтаар дамжуулан багш, сайн дурын ажилтан, хөдөө аж ахуйн удирдагчид зэргийг бэлтгэдэг байна. Эдгээр академийг төгсөгчид нь хотын үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцож, хотын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулдаг байна. 2011 онд “Эрдмийн цамхаг” хөтөлбөрт дөнгөж 835 хүн оролцож байсан бол 2014 онд 10402 болтлоо өссөн байна. “Эрдмийн цамхаг” төвөөс 640 төрлийн хичээл заадаг болжээ. Эрдмийг дээдэлдэг энэ хот иргэн нэг бүрийнхээ амьдралынхаа туршид суралцах нөхцлийг ийнхүү бүрдүүлж, бүх талаар дэмждэг байна.

МАНАЙ ОРОНД НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖҮҮД

- 1** Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр, үзэл баримтлал боловсруулах. Иргэн бүр амьдралынхаа турш үргэлжлүүлэн суралцаж, нийгмээрээ, улс даяараа мэдлэгийг дээдлэн, түүнийхээ үр өгөөжийг мэдэрч, сэтгэл ханамжтай амьдрах эрхийг хангах, нөхцлийг бүрдүүлэхэд насан туршийн боловсролын философийн мөн чанар оршдог. Манай орны нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал насан туршийн боловсролыг хөхүүлэн дэмжих үндэсний хөтөлбөр, үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тавьж байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь дараах асуудлыг хамарсан байх нь зүйтэй юм.
- A** Хүн бүрийн сурч боловсрох эрхийг насан туршийн боловсролын тогтолцоо бүрдүүлэн хангах.
 - B** Насан туршийн боловсрол бол албан, албан бус, амьдрал дээр бие даан суралцах гэсэн 3 хэлбэртэйг хүлээн зөвшөөрч, сүүлийн хоёр хэлбэрийг улам хөгжүүлж бэхжүүлэх эрх зүйн асуудлыг шийдвэрлэх.
 - C** Их дээд сургуулиудаас насан туршийн боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажлуудыг явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх. Үүнд, мэргэжил дээшлүүлэх урт богино хугацааны сургалт явуулах, дээд шатны (executive) сургалт, олныг хамарсан онлайн нээлттэй сургалт явуулах ажлыг бүх талаар дэмжих.
 - D** Сургалтын нөөц материалыг онлайн хэлбэрээр нээлттэй олны хүртээл болгох ажлыг төрөөс тодорхой бодлогоор дэмжиж, тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх.
 - E** Одоо байгуулагдан ажиллаж байгаа “Гэгээрэл” болон ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төвүүдийн үйл ажиллагааг улам бэхжүүлж, хүмүүнлэг нийгэм байгуулахад тэдний оруулах хувь нэмрийг дээшлүүлж, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх.
 - F** Дээд боловсролын дипломтай ажил эрхлээгүй хүмүүст зах зээлд өрсөлдөхүйц мэдлэг, ур чадвар олгох, шинэ мэргэшил эзэмших боломжоор хангах орчин нөхцлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд дорвитой хувь нэмэр оруулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх.
 - G** Сурах нөхцөл боломжоор дутмаг эмзэг давхаргын хүмүүст мэдлэг чадвар олгох нөхцлийг насан туршийн боловсролоор дамжуулан бүрэн шийдэх.
 - H** Албан бус болон амьдрал дээр бие даан суралцаж олж авсан мэдлэг чадвар, чадамжийг баталгаажуулах механизмыг тодорхой зааж өгөх нь тухайн бодлогын баримт бичгийн нэг чухал хэсэг болох юм.



2 Гэр бүлийн хүрээнд болон ажлын байр, олон нийтийн газар сурах орчныг бий болгож, бүх боломжит нөөцийг төвлөрүүлж эрдэм оюунлаг хотуудыг бий болгох талаар орон нутгийн удирдлагын санаачлагыг бүрэн дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

3 Эрдэм мэдлэг нээлттэй болж байгаа өнөө цагийн дуудлагын дагуу Монголын анхны нээлттэй их сургуулийг өмчийн хэлбэр харгалзахгүй байгуулах ажлыг бүх талаар дэмжих. Боловсролын тухай хуульд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж өгөх.



ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

- Collection of Lifelong Learning Policies and Strategies. UNESCO UIL. <http://uil.unesco.org/lifelong-learning/life-long-learning-policies-database>
- Delors, J. et al. 1996. Learning: the treasure within; report to UNESCO of the International Commission on Education for the 21st Century. Paris, UNESCO.
- European Commission. 2000. Memorandum on lifelong learning. [online] Available at: http://arhiv.acs.si/dokumenti/Memorandum_on_Lifelong_Learning.pdf
- European Council. 2002. Council resolution on lifelong learning. [online] Available at: <http://eurlex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:C:2002:163:0001:0003:EN:PDF>
- European Parliament. 2006. Commission proposal for the introduction of a new action program to promote lifelong learning in the 2007-2013 period. [online] Available at: <http://eur-lex.europa.eu/legalcontent/EN/TXT/?uri=CELEX:32006D1720>
- Faure, E. et al. 1972. Learning to Be: the world of education today and tomorrow. Paris, UNESCO.
- Field, J. 2006. Lifelong Learning and the New Educational Order. Stoke on Trent, Trentham Books.
- Philip H. Coombs. The world crisis in education: A Systemic Analysis. Oxford University Press. 1968

SUMMARY

It is difficult to overstate the significance of lifelong learning in contemporary society. This edition of the policy briefs on Lifelong Learning gives a comprehensive and research-informed introduction to issues in this field. Governmental, institutional and individual commitments to lifelong learning have brought changes in the meaning and significance of learning across the life course and new teaching and learning practices, as well as significant institutional change. The vision of the learning society and learning cities that is unfolding is highlighted. The policy brief cover the various conceptions of lifelong learning; the factors that impinge on learning through the life course; the social and the economic rationale for lifelong learning; the varied modalities of lifelong

learning, from apprenticeship to adult learning, distance education to MOOC etc,. The policy brief provides a set of policy recommendations and policy choice for promoting a lifelong learning. This timely overview will be relevant to policy makers, education and training professionals in all education sectors, education studies students and the general reader.

The International Center for Higher Education Research of the Mongolian University of Science and Technology presents research-based information in a brief and concise format targeted policy makers and researchers. Readers are encouraged to make reference to the briefs or the underlying research publications in their own publications, and promotion, critical thinking, innovation and creativity.

ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

